



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2010 оны 10 сарын 26 өдөр

Дугаар 375

Улаанбаатар хот

Томуугийн цартахлын А(Н1N1) вирусийн  
халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах  
тухай

Томуугийн цартахлын А(Н1N1) вирусийн халдвараас сэргийлэх зорилгоор  
ТУШААХ нь:

1. Томуугийн цартахлын А(Н1N1) вирусийн халдварын эсрэг вакцин, тариур, аюулгүй хайрцгийн хуваарийг нэгдүгээр, Вакцин тарих зааврыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Томуугийн цартахлын А(Н1N1) вирусийн халдварын эсрэг вакцинаар 6-65 насны хүн амыг сайн дураар дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү), Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.

3. Уг вакцинаар дархлаажуулсан тухай мэдээ, тайланг сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон Халдварт өвчин судлалын үндэсний төвд ирүүлж байхыг Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (С.Төгсдэлгэр), Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Ш.Энхбат)-т даалгасугай.



С. ЛАМБАА

82

Эрүүл мэндийн сайдын 2010 оны .... 10 дугаар сарын 26 ны өдрийн 375 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

Томуугийн цартахлын А(Н1N1) вирусийн халдварын эсрэг вакцин, тариур, аюулгүй хайрцгийн хуваарь

| Д/д | Байгууллагын нэрс                              | Шаардагдах вакцин /хүн тун/ | Шаардагдах найруулдаг тариур /5.0 мл/ | Шаардагдах тариур /0.5 мл/ | Шаардагдах аюулгүй хайрцаг |
|-----|------------------------------------------------|-----------------------------|---------------------------------------|----------------------------|----------------------------|
| 1   | Архангай аймгийн ЭМГ                           | 9000                        | 990                                   | 9450                       | 105                        |
| 2   | Баян-өлгий аймгийн ЭМГ                         | 9300                        | 1025                                  | 9770                       | 110                        |
| 3   | Баянхонгор аймгийн ЭМГ                         | 8000                        | 880                                   | 8400                       | 95                         |
| 4   | Булган аймгийн ЭМГ                             | 5900                        | 650                                   | 6200                       | 70                         |
| 5   | Говь-Алтай аймгийн ЭМГ                         | 5600                        | 620                                   | 5900                       | 70                         |
| 6   | Говь-Сүмбэр аймгийн ЭМГ                        | 1400                        | 160                                   | 1500                       | 20                         |
| 7   | Дархан-Уул аймгийн ЭМГ                         | 9100                        | 1110                                  | 9600                       | 110                        |
| 8   | Дорноговь аймгийн ЭМГ                          | 5800                        | 650                                   | 6150                       | 70                         |
| 9   | Дорнод аймгийн ЭМГ                             | 7400                        | 820                                   | 7800                       | 90                         |
| 10  | Дундговь аймгийн ЭМГ                           | 4800                        | 530                                   | 5100                       | 60                         |
| 11  | Завхан аймгийн ЭМГ                             | 7500                        | 850                                   | 8000                       | 90                         |
| 12  | Орхон аймгийн ЭМГ                              | 10000                       | 1150                                  | 11000                      | 125                        |
| 13  | Өвөрхангай аймгийн ЭМГ                         | 11000                       | 1210                                  | 11600                      | 130                        |
| 14  | Өмнөговь аймгийн ЭМГ                           | 5100                        | 570                                   | 5400                       | 60                         |
| 15  | Сүхбаатар аймгийн ЭМГ                          | 5500                        | 610                                   | 5800                       | 65                         |
| 16  | Сэлэнгэ аймгийн ЭМГ                            | 10000                       | 1100                                  | 10500                      | 120                        |
| 17  | Төв аймгийн ЭМГ                                | 8800                        | 970                                   | 9300                       | 105                        |
| 18  | Увс аймгийн ЭМГ                                | 7800                        | 860                                   | 8200                       | 95                         |
| 19  | Ховд аймгийн ЭМГ                               | 8300                        | 930                                   | 8750                       | 100                        |
| 20  | Хөвсгөл аймгийн ЭМГ                            | 12000                       | 1320                                  | 12600                      | 145                        |
| 21  | Хэнтий аймгийн ЭМГ                             | 7000                        | 770                                   | 7400                       | 90                         |
| 22  | Сүхбаатар аймгийн ЭМН                          | 13350                       | 1470                                  | 14100                      | 160                        |
| 23  | Чингэлтэй дүүргийн ЭМН                         | 14000                       | 1560                                  | 14750                      | 165                        |
| 24  | Хан - Уул дүүргийн ЭМН                         | 9900                        | 1150                                  | 10500                      | 120                        |
| 25  | Баянгол дүүргийн ЭМН                           | 17000                       | 2570                                  | 17900                      | 205                        |
| 26  | Сонгинохайрхан дүүргийн ЭМН                    | 23000                       | 2600                                  | 24200                      | 270                        |
| 27  | Баянзүрх дүүргийн ЭМН                          | 23000                       | 2600                                  | 24200                      | 270                        |
| 28  | Налайх дүүргийн ЭМН                            | 3000                        | 350                                   | 3150                       | 35                         |
| 29  | Багануур дүүргийн ЭМН                          | 3000                        | 350                                   | 3150                       | 35                         |
| 30  | Багахангай дүүргийн ЭМН                        | 500                         | 60                                    | 530                        | 6                          |
| 31  | Төмөр замын эмнэлэг                            | 1000                        | 100                                   | 1050                       | 11                         |
| 32  | Клиникийн 2 дугаар эмнэлэг                     | 100                         | 10                                    | 105                        | 2                          |
| 33  | Зэвсэгт хүчний жанжин штабын эмнэлэг           | 4710                        | 475                                   | 4950                       | 55                         |
| 34  | ХӨСҮТ –ийн сайн дурын дархлаажуулалтын кабинет | 1000                        | 120                                   | 1100                       | 13                         |
| 35  | ХӨСҮТ-ийн нөөцөнд                              | 27140                       | 3460                                  | 39600                      | 430                        |
| 36  | БҮГД                                           | 300000                      | 34650                                 | 327705                     | 3702                       |

Тайлбар:

Вакцины хорогдлыг 1.1 - ээр, зорилтот бүлгийг тухайн нутгийн хүн амын 10 хувиар тус тус тооцсон.

Эрүүл мэндийн сайдын 2010 оны .... 10 дугаар  
сарын 26 ны өдрийн 73 тоот тушаалын  
хоёрдугаар хавсралт

### Томуугийн цартахлын А(Н1N1) вирусийн халдварын эсрэг вакциныг тарих заавар

#### Тодорхойлт:

Томуугийн цартахлын А(Н1N1) вирусийн халдварын эсрэг вакцин /Пандемрикс/ нь идэвхгүйжүүлсэн томуугийн сплит вирус, өндгөнд өсгөвөрлөсөн А/California/7/2009 (H1N1)v төст омгийн антиген 3.75 мкг, 5 мкг тиомерсал агуулсан.

#### Хэрэглэх арга, тун:

Хүүхэд, насанд хүрэгсдэд (10-аас дээш нас) 0.5 мл-ээр тарина. Вакцин хийлгэснээс хойш 3 долоо хоногийн дараа дархлаа тогтоно.

Бага насны хүүхдүүдэд (6 сараас 9 нас) 0.25 мл-ээр тарина. 3 долоо хоногийн дараа 0.25 мл-ээр 2 дах тунг тарина. Вакциныг дельтойд хэлбэрийн булчин эсвэл гуяны гадна талын булчинд тарина.

#### Вакциныг найруулах:

- “Пандемрикс” вакцин нь 2 тусдаа суспенз болон эмульс хэлбэрээр савлагдсан.
- Эмульс /хүчлүүр/, суспенз /антиген/-ийг холихын өмнө тасалгааны температурт 5-10 минут байлгаж, тус тусад нь сэгсрээд, бүрэн бүтэн байдлыг сайтар шалгана. Хэрвээ флакон гэмтэлтэй байвал хэрэглэхгүй.
- Хүчлүүр нь цайвар өнгөтэй, антиген нь өнгөгүй шингэн. 1 флакон 2,5 мл хүчлүүрийг 2,5 мл 1 флакон антигентэй хольж найруулахад 5 мл 10 хүн тун вакцин болно.
- Хүчлүүрийг сэгсэрсний дараа тариурт соруулан антигентэй флаконд хийнэ.
- Антиген болон хүчлүүрийг хольж сайтар сэгсэрнэ. Найруулсан вакцин нь цайвар өнгөтэй эмульс болно. Вакцины өнгө өөрчлөгдсөн тохиолдолд хэрэглэхгүй.
- Тарилга бүрийн өмнө найруулсан вакцинтай флаконыг сэгсэрч, ямар нэг өөрчлөлт орсон эсэхийг сайтар шалгана.

#### Эсрэг заалт:

- Вакцины найрлаганд орсон ямар нэгэн бодист (өндөг, тахианы уураг, өндөгний шар, формальдегид, гентамицин сульфат, деоксихолат сода) харшилтай хүн,

- Урьд нь ямар нэгэн вакцинд харшлын урвал, анафилактик шок өгч байсан болон хэт мэдрэг хүн.

Дархлаажуулалтын дараах урвал:

Вакциныг тарьсны дараа толгой, үе мөч, булчин өвдөх, тарьсан газар улайх, хавдах, халуурах, тунгалагийн булчирхай бага зэрэг томрох зэрэг шинж тэмдгүүд гарч болох бөгөөд 2-3 хоногийн дараа эмчилгээгүйгээр арилна. Түүнчлэн бөөлжих, тууралт гарах, толгой эргэх зэрэг шинж тэмдэг ховор тохиолдоно.

Анхааруулга:

Вакцин тарихын өмнө эмчийн үзлэг хийнэ. Шаардлагатай үед эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх бэлэн байдлыг хангасан байна. "Пандемрикс" вакциныг бусад вакцинтай нэгэн зэрэг хийхгүй.

Хадгалах хугацаа:

Вакциныг найруулснаас хойш 6 цагийн дотор хэрэглэнэ. Найруулсан вакциныг 25-аас дээш хэмд хадгалж болохгүй.

Хадгалах хэм:

2 – 8 хэм, Вакциныг хөлдөөж болохгүй.

Вакциныг үйлдвэрлэсэн: Бельги улс, Глаксо Смит Клайн Вакцины Үйлдвэр.